



## GLENVIEW SCHOOL DISTRICT 34

1401 Greenwood Road  
Glenview, Illinois 60026  
www.glenview34.org

Эрхэм хүндэт эцэг эх / асран хамгаалагч нарт:

Glenview 34-р Дүүргийн сургуульд Тавтай Морилно уу!

Та манай боловсролын салбарын нэгэн гэр бүл болж байгаад бид баяртай байна. Иллинойс мужийн хуулиар бүх сургуулийн Дүүргүүд шинээр элсэн орж байгаа бүх сурагчдад дараахь журмыг дагаж мөрдөхийг шаарддаг.

1. Glenview хотын улсын сургуульд сурагч анх элсэн ороход, сургуульд анхлан суралцаж байгаа (сургуулийн өмнөх насны анги) эсвэл шилжин ирж байгаагаас үл хамааран **сурагчийн төрсний гэрчилгээний баталгаажуулсан хуулбар байх шаардлагатай**. Гэрчилгээний хуулбарыг сурагчийн албан ёсны бүртгэлийн хувийн хэрэгт хадгална. **Хэрэв төрсний гэрчилгээний баталгаажуулсан хуулбар байхгүй** бол төрсний гэрчилгээг бүрдүүлэх боломжгүйгээ тайлбарласан, нотариатаар баталгаажуулсан (эрх бүхий шүүгч, албан тушаалтны өмнө тангараг өргөн, бичгээр үйлдсэн батламж) мэдэгдлийг дараах 2 баримт бичгийн аль нэгийн хамт бүрдүүлнэ:
  - a) эмнэлгийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар, эсвэл
  - b) бусад улсын паспорт, виз
2. Төрсний гэрчилгээний талаарх энэхүү баримт бичгийг энэ мэдэгдлийг авснаас хойш 30 хоногийн дотор баримт бичгийн хамт бүрдүүлэн өгөх шаардлагатай. Хэрэв энэ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд сургуулийн Дүүрэг энэ талаар Glenview -ийн Цагдаагийн газар, Иллинойс мужийн Цагдаагийн газарт мэдэгдэх шаардлагатай болно.

Хэрэв танд энэхүү шаардлагын талаар асуух зүйл байвал сургуулийн захиралтай холбоо барина уу.

Хүндэтгэсэн,

Доктор Дэйн Делли,  
Тэргүүн Удирдагч